

1. "АЯН ЗАМЫН БОДОЛ БУЮУ УЯНГЫН ЭРХИ"- эхээс онцолсон өгүүлбэр хэрхэн холбогдсон бүтэц хэв шинжийн хувьд ямар өгүүлбэр болохыг тодорхойлж, энгийн өгүүлбэр болгон задлан бичээрэй. (4 оноо)
  - Зэрэгцэхийн Ж нөхцөлөөр холбогдсон
  - ЗНӨ
  - Угалзын зоо шиг энэ хөх халзан даваа эртний жингийн замыг мөрлөн өргөнө.
  - аянчин жуулчинд Отгон тэнгэрийн оргилыг зориуд харуулах гэсэн шиг.
2. Учралдах, найрсах гэсэн үгийн утгыг тольчлон тайлбарлаарай. (4 оноо)
  - Учралдах харилцан учрах, учрал тохиох
  - Найрсах- зохицох, нийлэх
2. Дараах бүтээврүүдийг утгатай нь зөв харгалзуулан бичээрэй. (4 оноо)
 

А. Магц <sup>4</sup>	1. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын ЗЭРЭГЦЭХИЙН НӨХЦӨЛ
Б. Нгуут <sup>2</sup>	2. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын УГТАХЫН НӨХЦӨЛ
В. ж,ч	3. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын БЭЛТГЭХИЙН НӨХЦӨЛ
Г. Тал <sup>4</sup>	4. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын ДАЛИМДАХЫН НӨХЦӨЛ

**А3, Б4, В1, Г2**

3. Зөв бичгийн дүрмийн алдаатай 4 үгийг олж, засаж бичээрэй. (2оноо)

Намайг **нутгын** улс бараадуулж өгөөд Цогоо ах шагай зээрдээ хөтлөн зам салан давхиж одлоо. Будар будар тоос нь миний цээжинд суунаглана. Аргагүй шүү дээ, миний ах биш юм чинь. "**Эрхлэж** дагадаг бага зээрд минь танихгүй хүнд хөтлүүлэн хаа газар янцгааж яваа бол" хэмээн санахад би дотуур **мэгшнэ**. Их хоёр загал ч гэсэн дээ. Буга хайрхныхаа мөнх цасны усаар ундаалж өссөн **болхоор** бусдын газрын ногоо нь хүртэл амнаас нь унаж байгаа биз.

а.....нутгын..... нутгийн.....  
 б.....эрхлэж..... эрхэлж.....  
 в.....мэгшнэ..... мэгшинэ.....  
 г.....болхоор..... болохоор.....

5. Дээрх алдааг засаж бичсэн нэг үгийг сонгон зөв бичих дүрмийг тайлбарлан бичээрэй. (2 оноо)

Хэрхэн тайлбарласныг харгалзан оноо өгөөрэй.

6. А.Доде "Сүүлчийн хичээл зохиолоос түүхийн хам сэдвийг тодорхойлох (5оноо)  
 А.Өгүүллэгээс Германчуудтай холбоотой орчны дүрслэлийг бичээрэй.  
 •Тэр өглөө цэв цэлмэг, аагим халуун байсныг ч хэлэх үү. Модны заводын цаадах, германчуудын жагсаалын бэлтгэл хийдэг Ринерийн нугад болон ойн захаар хөөндэйн жиргэх дуун сонсогдоно. •Сүүлийн хоёр жил энэ самбараас дайны ялагдал, албадан авах, комендатын тушаал гээд л өөдтэйбиш мэдээг дуулдагсан. Эльзас ба Лотарингийн сургуулиудад зөвхөн герман хэл заах шийдвэр Берлинээс ирсэн. Шинэ багш чинь маргааширнэ..  
 Б Ямар учраас Амель багш "Өнөөдөр франц хэлний сүүлчийн хичээл" гэж хэлсэн бэ? Эльзас ба Лотарингийн сургуулиудад зөвхөн герман хэл заах шийдвэр Берлинээс ирсэн учраас энэ үгийг хэлсэн.
7. Рубай шүлэг дэх тодруулсан үгийн утгыг хам сэдвийн хүрээнд тайлбарлаж, шүлгийг тодорхойлон далд утгыг тайлбарлаарай. (2 оноо)

Чандар-үнс, шарилын үнс

Тоосго-барилгынматериал, туйпуу

Сууц-Байр, оршин суух газар

Далд утга

Аливаа зүйл устаж үгүй болохгүй, шинээр бий болохгүй, нэг нь нөгөөгөө бий болгож байдаг.

8. Галидасын “Үүлэн зардас” найраглалын дараах эшлэлийн утгыг хэрхэн тайлбарлаж болох вэ? (2 оноо)

Хариулт: Салхи үүлийг хэзээ ч тууж чадахгүй. Үүл нь дүүрэн байдаг учраас салхи тууж дийлэхгүй.

9. Үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй.(5 оноо)

ᠮᠤᠰᠢᠮᠤ ᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ  
ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ  
ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ  
ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ  
ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ  
ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ ᠮᠤᠨᠯᠢᠭᠢᠰᠤ

Алдаатай үгийн тоогоор 0,25 оноо хасаж өгнө.

10. Аян замын тэмдэглэл бичээрэй. (10оноо) (үгийн тоо 200-220)

Дараах шалгуурыг баримтлаарай.

- а. Үйл явдлыг нэг бүрчлэн тоочин тайлбарласан
- Б. Гадаад дотоод талыг зураглан тоочиж тайлбарласан
- В. Өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байх
- Г.Уран дүрслэл, хэлц үг хэллэг ашигласан байх
- Д.Үгийн тоо хязгаарласан хэмжээнд байх
- Е. Гаргацтай, алдаагүй бичсэн байх

**Отгонтэнгэрийн оргил шиг хүрэхүйеэ бэрх бөгөөд үргэлж даллан дуудаж, ойртохын хэрээр улам өндөр болдог ажээ.**

1. "АЯН ЗАМЫН БОДОЛ БУЮУ УЯНГЫН ЭРХИ"- эхээс онцолсон өгүүлбэр хэрхэн холбогдсон бүтэц хэв шинжийн хувьд ямар өгүүлбэр болохыг тодорхойлж, энгийн өгүүлбэр болгон задлан бичээрэй. (4 оноо)

**Бөгөөд холбоос  
ЗНӨ**

**Отгонтэнгэрийн оргил шиг хүрэхүйеэ бэрх...  
үргэлж даллан дуудаж, ойртохын хэрээр улам өндөр болдог ажээ.**

2. Эсэргүүцэх, тэмцэлдэх гэсэн үгийн утгыг тольчлон тайлбарлаарай. (4 оноо)

- эсрэг хариу үзүүлэх, тэмцэх

- тэмцэлдэх- тэмцэх, үйл хэргийн төлөө хоёр тал болон маргах, мэтгэх.

3. Дараах бүтээврүүдийг утгатай нь зөв харгалзуулан бичээрэй. (4 оноо)

А. хлаар<sup>4</sup>

Б. Нгаа<sup>2</sup>

В. н

Г. Саар<sup>4</sup>

А 4, Б 1, В 2, Г 3

1. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын ТАШРАМДАХ НӨХЦӨЛ

2. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын ХАМЫН НӨХЦӨЛ

3. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын ҮРГЭЛЖЛЭХИЙН НӨХЦӨЛ

4. Үйлийн нөхцөлдүүлэн холбохын ДАГАЛДАХЫН НӨХЦӨЛ

4. Зөв бичгийн дүрмийн алдаатай 4 үгийг олж, засаж бичээрэй. (2оноо)

**Ганзагийн** наймаа ид цэцгэлж, Эрээн, Хөх хот, Бээжин Улаанбаатарын хооронд Монгол, Хятад хүмүүсийн хөл **тасархаа** болижээ. Би наймаа арилжаанд дөргүй ч, хэдэн хониныхоо ноос, арьс, махыг замын панзчингуудад хэр тааруу үнээр өгч, эгэл **амьдарлаа** болгодог. Хэдэн бор юм илүүчилснийх толгойтой болгон мөрөө гаргахыг хүсдэг, бас өндөр **өвөгийн** ханыг нь тулаад буцсан урт Цагаан хэрмийг үзмээр санагдаад болдоггүй. Ингээд л гутлаа ганзагалан дотор газрыг зорьсон билээ.

1. Ганзагийн

ганзагын

2. Тасархаа

тасрахаа

3. Амьдарлаа

амьдралаа

4. Өвөгийн

өвгийн

5. Дээрх алдааг засаж бичсэн нэг үгийг сонгон зөв бичих дүрмийг тайлбарлан бичээрэй. (2 оноо)

Аль нэг үгийн ЗБД-ийг тайлбарлан бичих.....

6. А.Доде "Сүүлчийн хичээл зохиолоос хүүгийн сэтгэлзүйг өөрчилсөн шалтгааныг олж тайлбарлаарай. (5 оноо)

**Хүү гайхширсан.**

Би энэ шуугианы дундуур суудалдаа сэмхэн суучихна гэж бодож байсан чинь тэр өдөр бүр нам гүм,яг л бүтэн сайн өдрийн өглөө шиг байсан шүү. Нээлттэй цонхоор харсан чинь нөхөд маань суудалдаа суучихсан, Амель багш аймшигтай төмөр шугамаа бариад цааш нааш холхиж байлаа.

**Хүүгийн сэтгэл дэнсэлсэн.**

Хүүхдүүдээ, би та нартай сүүлчийнхээ хичээлийг хийж байна. Эльзас ба Лотарингийн сургуулиудад зөвхөн герман хэл заах шийдвэр Берлинээс ирсэн.Шинэ багш чинь маргааш ирнэ... Өнөөдөрфранц хэлний сүүлчийн хичээл. Анхааралтай суухыг хүсье гэлээ.

7. Галидасын "Үүлэн зардас" найраглалын дараах эшлэлийн утгыг хэрхэн тайлбарлаж болох вэ? (2 оноо)

"Усан төгс баригч чамайг үнэр хөлөглөгч үл хөдөлгөнөм

Угаас хоосон юм хөнгөн, хүнд юм жинтэй байдаг"

Хариулт: Салхи үүлийг хэзээ ч тууж чадахгүй. Үүл нь дүүрэн байдаг учраас салхи тууж дийлэхгүй.

8. Хайку шүлэг дэх тодруулсан үгийн утгыг хам сэдвийн хүрээнд тайлбарлаж, шүлгийг тодорхойлон далд утгыг тайлбарлаарай. (2 оноо)

Хэзээ ч мартагдахгүй

**Ганцаардлын амт**

**Цагаан шүүдэр**

Ганцаардах-ганцаар байх

Амт-дур сонирхол

Шүүдэр-усны уур өвс ургамлын толгойд бөнжигнөх

9. Үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй. (2 оноо)

ᠮᠠᠨᠤᠯᠠᠭᠤᠨ ᠶ᠋ᠢᠨᠪᠠᠭᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ  
ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

Алдаатай үгийн тоогоор 0,25 оноо хасаж өгнө.

10. Аян замын тэмдэглэл бичээрэй. (10 оноо) (үгийн тоо 200-220)

Дараах шалгуурыг баримтлаарай.

- а. Үйл явдлыг нэг бүрчлэн тоочин тайлбарласан
- Б. Гадаад дотоод талыг зураглан тоочиж тайлбарласан
- В. Өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн байх
- Г. Уран дүрслэл, хэлц үг хэллэг ашигласан байх
- Д. Үгийн тоо хязгаарласан хэмжээнд байх
- Е. Гаргацтай, алдаагүй бичсэн байх